

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 03-р сарын 01-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр:

“Галын голын төмөр бетон гүүр, 36.7 у/м /Дорнод, Цагаан-Овоо сум/

Тендер шалгаруулалтын дугаар: ЗТХЯ/201801011

Зам, тээврийн хөгжлийн яам нь МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь “XIV.1.1.37 Галын голын төмөр бетон гүүр, 36.7 у/м /Дорнод, Цагаан-Овоо сум/“-ын барилгын ажил гүйцэтгэх тухай **цахим** тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүрийг **50.000 /тавин мянга/** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 14–16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга, байгууллагын гэрчилгээний хуулбар
- Гүйцэтгэгчийн ажиллах боловсон хүчиний чадавхийн талаарх мэдээлэл /Голлох инженер техникийн ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага/
- Гүйцэтгэгчийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /Сүүлийн 3 жилийн буюу 2015, 2016, 2017 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, татварын байгууллагын тодорхойлолт/
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн нийлбэр нь 500.000.000 /таван зуун сая/ төгрөгөөс багагүй байх
- Сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: төмөр бетон гүүр барих, засварлах ажлын тусгай зөвшөөрөлтэй байх
- Тендерийн хамт 15.000.000 /арван таван сая/ төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 04 дүгээр сарын 02-ны 14.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 14.30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын байр 13, Зам, тээврийн хөгжлийн яам 401 тоот, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Хосгэрэл
Утас-62263207, факс- 11312315**